БАТЛАВ: Н.ЛХАГВАДОРЖ /СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА/

Захиалагч:

Ө.СУВДАА

/СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА/

Гүйцэтгэгч:

Б.УЛАМБАЯР

/"АМАРРЕ КОНСТРАКШН" ХХК-ий ЗАХИРАЛ/

**УХААЛАГ ХУДАГ, ШУГАМЫН ЗАСВАРЫН АЖИЛ /СҮХБААТАР СУМ, 6-Р БАГ/ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

№ СЭА01-079/2021

2021.12.17

Сүхбаатар сум

Нэг талаас **Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар** түүнийг төлөөлж Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнхжаргал (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас **"Амарре констракшн" ХХК** түүнийг төлөөлж захирал Б.Уламбаяр (цаашид "гүйцэтгэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр энэхүү гэрээг (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь: 2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих **"Ухаалаг худаг, шугамын засварын ажил /Сүхбаатар сум, 6-р баг/"** (цаашид "ажил" гэх) ажлыг 49 688 795 /Дөчин есөөн сая зургаан зуун наян найман мянга долоон зуун ерэн таван/ төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний нийт дүн: 49 688 795 төгрөг.

   Үүнээс:

   | | |
   |---|---|
   | Техник хяналтын зардал | – 839 829 төгрөг |
   | Зураг төсвийн үнэ | - 1 303 020 төгрөг |
   | Зохиогчийн хяналтын зардал | - 419 915 төгрөг |
   | Магадлашгүй ажлын зардал | - 839 829 төгрөг |

4. Гүйцэтгэгч нь: "Ухаалаг худаг, шугамын засварын ажил /Сүхбаатар сум, 6-р баг/" ажлыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр эхэлж, 2021 оны 12 дүгээр сарын 30-ны өдөр ашиглалтад оруулна.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

   Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   Бусад шаардлагатай баримт бичиг;
   Тендер;
   Гэрээний тусгай нөхцөл;
   Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт;
Зураг, төсөв;
Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь:
Санхүүжилтийн хуваарь;
Ажил гүйцэтгэх хуваарь.
Инженер техникийн ажилтнуудын жагсаалт

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дараалын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Мөнхжаргал

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Б.Янжинлхам

*Хаяг: Монгол Улс. Сэлэнгэ аймаг Сүхбаатар сум аймгийн ЗДТГазар*
Утас:70363793, 99929367
Харилцах банк:
Дансны дугаар:

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"Амарре констракшн" ХХК-ий захирал

Б.Уламбаяр

*Монгол Улс. Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 6-р баг, 2-р хэсэг, 7-13 тоот*
Утас: 94110525, 99826300
Мэйл хаяг: d7.umba@gmail.com
Харилцах банк: Хаан банк
Дансны дугаар:5692029344
Регистрийн дугаар: 3749924

# ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолын дагуу дотоодын болон Сэлэнгэ аймагт үйлдвэрлэгдэж байгаа бараа материалыг авч ашиглах, үйлдвэрлэгчдээс авч ашигласан бараа материалын тайлан мэдээг гүйцэтгэлийн бичиг баримтад хавсаргах.

2. Орон нутгаас ажилчид авч ажиллуулах, ажиллуулсан тухай тайлан мэдээг гүйцэтгэлд хавсаргах.

3. Хөрөнгө оруулалтын ажилд ашиглагдах бараа материал сонголт, тоног төхөөрөмж хийц эдлэлийн өнгө, загварыг захиалагч болон ашиглагчтай зөвшилцөн сонгох.

4. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн материалыг Сангийн сайдын 282 дугаар тушаалын дагуу бүрдүүлж ирүүлэх бөгөөд гүйцэтгэл бүрт ашиглагчаас тодорхойлолт авч хавсаргах шаардлагатай.

**1.1** Захиалагч: Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар

**1.1** Төслийн менежер: Б.Мөнхжаргал /Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар 111 тоот өрөө/

**1.1** Гэрээний нэр болон бүртгэлийн батлагдсан дугаар: "Ухаалаг худаг, шугамын засварын ажил /Сүхбаатар сум, 6-р баг/"-ыг СЭА01-079/2021

**1.1** Ажил эхлэх өдөр: 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр

**1.1** Ажлын талбай нь: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум

**3.0** Гэрээний баримт бичгүүд нь Монгол хэл дээр байна.

**3.0** Гэрээнд Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.

**17, 26** Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр дуусган хүлээлгэн өгөх

**25.0** Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш **7** хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.

**25.0** Ажлын хөтөлбөрийг **10** хоног тутам тодотгоно.

**32.0** Чанарын баталгаат хугацаа ***365*** хоног байна.

**46.0** Гүйцэтгэгч гэрээний хугацааг хэтрүүлсэн тохиолдолд алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,05 байна.

**46.0** Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн ***10 хувь*** байна. Алдангийг ажил гүйцэтгэх үе шатны графикаар тооцох бөгөөд нийт алдангийн хэмжээ гэрээний дүнгийн 10 хувьд хүрсэн тохиолдолд гэрээ цуцлагдах үндэслэл болно.

| | |
|---|---|
| **47.0** | Нийт ажилд олгох урамшууллын дээд хэмжээ нь гэрээний үнийн ***0 хувь*** байна. |
| **48.0** | **Урьдчилгаа төлбөр олгохгүй, ажлын гүйцэтгэл 80 хувьд хүрэхэд 1 дэх санхүүжилт гэрээний дүнгийн 80 хувийн санхүүжилт, ажлыг бүрэн хүлээлгэн өгсөний дараа сүүлийн үлдэгдэл санхүүжилт 20 хувийг олгоно.**<br>**Төсвийн хүндрэлээс шалтгаалан санхүүжилт тасрах, удааширсан тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр гэрээт ажлыг хугацаанд нь дуусгаж хүлээлгэн өгөх санхүүгийн чадвартай байна.** |
| **49.0** | Гүйцэтгэлийн баталгаа гэрээний дүнгийн 6 хувь. |
| **49.0** | Магадлашгүй ажлын санхүүжилтийг гүйцэтгэл, хүлээлгэн өгсөн актыг үндэслэн олгоно. |
| **55.0** | Гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан актыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны дотор гаргаж өгнө. |
| Мэдээлэл | Гүйцэтгэгч нь гэрээний хэрэгжилтийн тайлан мэдээллийг www.Shilendans.gov.mn сайтад байршуулах |

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Я.Мөрөн

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"Амарре констракшн" ХХК-ий захирал

Б.Уламбаяр